

# Сургалтын гэрээ

Суралцагч \_\_\_\_\_ ангийн оюутан \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_

## § 1 Ерөнхий зүйл

- "Аварга" ДС тус сургуульд суралцаж буй суралцагчтай сургалтын энэхүү гэрээг харилцан тохиролцон байгуулав.
- Сургууль, суралцагч 2 тал гэрээний үүргийг биелүүлэхдээ дагаж мөрдвөл зохих хууль, дүрэм,зааврыг мөрдлөг болгосон хуулийн этгээд болно.
- Гэрээний үүргийн биелэлтийг 2 тал хамтарч жил бүрийн хичээлийн жилийн эцэст дүгнэх сунгах бөгөөд гэрээний үүргийг биелүүлэх явцад үүссэн маргаантай буюу гэрээнд дурьдаагүй асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## § 2 Сургуулийн хүлээх үүрэг, хариуцлага.

- Мэргэжлийн эрдэмтэн профессор, багш нараар хичээл заалгаж,ном,сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл, анги танхим, спорт танхим заал, зэрэг шаардагдах нөхцлөөр хангана.
- Боловсролын хууль, дээд боловсролын хуулинд нийцүүлэн шавь төвтэй сургалт явуулна.
- Соёл хүмүүжлийн ажлыг төлөвлөгөөний дагуу зохиож,оюутны дунд зохиогдох урлаг,соёл хүмүүжил,спортын арга хэмжээг зохион байгуулах бололцоогоор хангана.
- Сургалтын жилийн төлбөрийг хоёр улирал дараалан онц сурагцвал 15%, дөрвөн улиралдараалан онц сурагцвал 25%-иар зургаан улирал дараалан онц сурагцвал 50% хөнгөлнө. (Бүх хичээлийн Р-91%-иас дээш байна)
- Эрдэм шинжилгээний хуралд итгэл тавьж шагналт байранд орвол 0,5 хүртэл кредит үнэлгээ өгнө.
- Сургуулийнхаа дүрэм,дотоод журмыг чанд мөрдөн биелүүлэх шаардлага тавьж хэрэгжүүлнэ.
- Сургалт хүмүүжлийн ажлыг хуваарийн дагуу чанартай явуулж сургалтанд кредит системийг нэвтрүүлэн, үр дүнг оюутанд тухай бүр мэдэгдэж байна.
- Оюутны зүгээс тавьсан санал хүсэлт хэрэгцээ шаардлагыг хүлээн авч,зохих хууль зүйн дагуу шуурхай шийдвэрлэнэ.
- Биеийн тамир спортын тэмцээн уралдаанд өндөр амжилт үзүүлсэн бол сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлнэ. Хөнгөлөлтийг дээд амжилтын үзүүлэлтээр хичээлийн жилийн төгсгөлд хөнгөлнө.

Үүнд:

| Тэмцээний төрөл  | Насанд хүрэгчид |       |       | Залуучууд |       |       | Өсвөр үе |       |       |
|--|-----------------|-------|-------|-----------|-------|-------|----------|-------|-------|
|  | Алт             | Мөнгө | Хүрэл | Алт       | Мөнгө | Хүрэл | Алт      | Мөнгө | Хүрэл |
| Дэлхийн аварга   | 100%            | 50%   | 30%   | 50%       | 40%   | 30%   | 40%      | 30%   | 20%   |
| Тивийн аварга шалгаруулах  | 50%             | 40%   | 30%   | 30        | 25%   | 20%   | 25%      | 20%   | 15%   |
| УАШТ   | 25%             | 20%   | 15%   | 10%       |       |       | 8%       |       |       |
| Үндэсний бөхөөр улсын цол авсан оюутнуудад 100%, аймгийн арслан цол авсан оюутнуудад 10% |                 |       |       |           |       |       |          |       |       |
| Монголын Оюутны Спортын Их Наадамд медаль хүртсэн бол 10%                                |                 |       |       |           |       |       |          |       |       |

## § 3 Оюутны хүлээх үүрэг хариуцлага

- Сургалтын төлөвлөгөө,хөтөлбөр,стандарт,сургуулийн дүрэм, журмыг чанд биелүүлж, сахилга баттай сайн суралцана. Шалгалт шүүлгийг тогтоосон хугацаанд нь өгнө.
- Багш шавийн уламжлалт ёсыг эрхэмлэн дагаж, ёс зүйтэй суралцаж, амьдарна.

3. Сургалтын төлбөрөө жил бүр хичээлийн жилийн эхний хагаст төлнө. Оюутны буруугаас шалтгаалж, сургуулиас хасагдвал төлсөн төлбөрийн үлдэх хэсгийг эргүүлж олгохгүй.
4. Сургуулийн хэмжээнд зохиогдох олон нийтийн ажилд идэвхтэй оролцоно.
5. Сургуулийнхаа анги танхим,эд хогшил,ном хэвлэл,тоног төхөөрөмжийг ариг гамтай эдэлнэ. Эвдэж үрэгдүүлбэл төлж, хохиролгүй болгоно.

#### **§ 4 Бусад зүйл**

1. Сургуулиас нэг жилийн чөлөө авч буй оюутнуудын сургалтын төлбөрийг буцааж олгохгүй.
2. Өөрийн хүсэлтээр гарч буй тохиолдолд хэрвээ хичээлийн жилийн эхний хагаст /1 сараас дээш хугацаагаар хичээлд суусан/ хичээллээд гарч буй бол хагас жилийн төлбөрийг, сүүлийн хагаст гарч буй бол жилийн төлбөрийг буцаан олгохгүй
3. Нэг сараас доош хугацаанд хичээлд суусан тохиолдолд тухайн хугацаанд суралцсан хугацааны сургалтын төлбөрийг суутгаж авна.
4. Сургуулиас өөрийн хүсэлтээр гарсан тохиолдолд томилолт хүчингүй болгосны төлбөр (тухайн жилийн сургалтын төлбөрийн 10%-иар тооцож) төлнө.
5. Сургуультай гэрээ байгуулж,гэрээний нэг хувийг өөртөө хадгална.

#### **Гэрээ байгуулсан:**

Улаанбаатар хот, 20\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

\_\_\_\_\_  
"Аварга" ДС-ийн сургалтын албаны дарга

\_\_\_\_\_  
"Аварга" ДС-ийн .....ангийн оюутан

\_\_\_\_\_  
Анги удирдсан багш